

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
(Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам)

/2017 оны хагас жил/

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө эх үүсвэр /сая.төг/	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилт хувиар
1	2	3	4	5	6	7	8	9
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
Зорилт 5. Геологи, уул уурхайн салбарын хөгжлийг дэмжиж, хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.								
5.1	МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.59 дэх заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	1. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 22 төслийн үр дүнг хүлээн авах	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:50000 масштаб/	37.0		1. Үр дүнгийн тайлантай 22 төслөөс 10 төслийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, сайдын А/107, А/106, А/61, А/60, А/59, А/57, А/56, А/02 дугаар тушаалуудаар хүлээн авсан. Ингэснээр нийт нутаг дэвсгэрийн 36.7% бүрэн хамрагдсан.	70%
			2. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 14 төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх				2. Үргэлжлэн хэрэгжих 14 төслөөс 2016 онд шинээр эхлэх 2 төслийг Сангийн яамны шийдвэрээр хэрэгжүүлээгүй. Ингэснээр 12 төслийг 2017 онд үргэлжлэн хэрэгжүүлэхээр сайдын А/96 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг батлан хээрийн судалгааны ажлыг эхлүүлээд байна.	100%
			3. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 4 төслийг шинээр хэрэгжүүлэх				3. Төсвийн хөрөнгөөр 2016 онд эхлэх 2 төслийг Сангийн яамны шийдвэрээр 2017 онд шинээр хэрэгжүүлэхтэй холбогдуулан энэ 2017 онд нийтдээ 6 төслийг шинээр хэрэгжүүлэхээр сайдын А/96 дугаар тушаалаар батлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байна.	40%
			4. Сэдэвчилсэн судалгааны				4. Төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлж дуусах Баруун Монголын цул сульфид-	70%

			Баруун Монголын цул сульфид-2014, Металло гени-2014, Геомэдээллийн сан-2013, Сансрын зургийн тайлалт-2013 төслүүдийг хэрэгжүүлж дуусган үр дүнг хүлээн авах				2014, Металлогени-2014, Геомэдээллийн сан-2013, Сансрын зургийн тайлалт-2013 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг сайдын А/96 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дээрх төслүүдийн ажлын аргачлал, хэмжээ, төсөвт тодотгол хийж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Үр дүнгийн тайланг жилийн эцэст хүлээн авна.	
			5. Төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлөвийн үнэлгээ-2017 төслийг шинээр эхлүүлэх				5. Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын ТЗМ-Алт-2017 төслийн геологийн даалгавар болон ажлын төлөвлөгөө, төсвийг сайдын А/96 дугаар тушаалаар баталсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа явагдаж байна.	40%
			6. “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” олон улсын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх				6. МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон.	100%
			7. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох 4 төслийн үр дүнг хүлээн авах	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:200000 масштаб/	100.0		7. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох 4 төслийн үр дүнгийн 4 тайланг хүлээн авахаас УГЗ-200-ТМ-VI төслийн үр дүнгийн тайланг сайдын А/108 дугаар тушаалаар хүлээн авсан. Үлдсэн 3 төслийн үр дүнгийн тайланг 3-р улиралд хүлээн авахаар ажиллаж байна.	70%
			8. Улсын геологийн 1:200000-ны				8. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтэх төсөл К хавтгайн хэмжээнд үргэлжлэн хэрэгжиж байна.	70%

			масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийг L хавтгайн хэмжээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх				Төслийн 2017 оны төсөв, төлөвлөгөөг сайдын А/96 дугаар тушаалаар баталсан.	
			9. Агаарын геофизикийн Алтай-I, II, Ховд-I төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх				9. Агаарын геофизикийн Алтай-1, Алтай-2, Ховд-1 төслүүдийн 2017 оны ажлын төлөвлөгөө, төсвийг сайдын А/96 дугаар тушаалаар баталж хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслүүд хэрэгжиж байна.	100%
5.2	МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24 дэх заалт	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэх	1. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлж, төслийн хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	20.0		1. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд далд уурхайн босоо амны малталтууд, хөндлөн нэвтрэлтүүд, туслах дэд бүтцийн ажлууд ахицтай үргэлжилж байгаа бөгөөд газрын гадарга руу гарах туузан дамжуургын болон үйлчилгээний налуу ам тус бүр 91 метр, 98 метрийн гүнд хүрээд байна. Далд уурхайн 2 дугаар босоо аманд 1284 метр нэвтрэлт хийхээс 1209 метр, 5 дугаар босоо аманд 1178 метр нэвтрэлт хийхээс 500 гаруй метрийн босоо нэвтрэлт хийгээд байна. Төслийн нийт капитал хөрөнгө оруулалтын төсөв 5.34 тэрбум ам доллар бөгөөд нийт тендер зарласан ажлын гэрээний үнийн дүн 1.32 тэрбум ам. долларт хүрсэн байна.	70%
			2. Тавантолгойн ордыг иж бүрэн, оновчтой ашиглах төсөл боловсруулах	Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлийг байгуулах ажлын явц, хувиар	100.0		2. Тавантолгойн ордыг бүрэн ашиглах ажлыг эрчимжүүлэх зорилгоор харьцуулсан судалгаа хийж, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/67-р тушаалаар байгуулан Эрдэнэс Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК -тай хамтран орд ашиглах харьцуулсан тооцоо, судалгааг хийж Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах боломжит хувилбарыг боловсруулсан.	40%

			3. Тавантолгойн ордыг иж бүрэн, оновчтой ашиглах төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх				3. Уул уурхай хүнд, үйлдвэрийн яамнаас “Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Яамд болон холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлээд байна.	40%
			4. Тавантолгойн ордыг иж бүрэн, оновчтой ашиглах төсөл боловсруулах				4. Мөн Энержи Ресурс компанийн Ухаа Худаг уурхайн 0-р давхаргын нүүрстэй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Цанхийн баруун хэсгийн 3, 4, 0-р давхаргын чанар муутай нүүрсийг хольж баяжуулан үр дүнг тодорхойлох үүргийг УУХҮ-ийн сайдаас Эрдэнэс Таван Толгой болон Энержи Ресурс компаниудад өгсний дагуу тус компаниуд анхдагч хэлэлцээрийг эхлүүлээд байна. Монгол Улсын Уул уурхайн яам /хуучнаар/, Япон Улсын Шинэ эрчим хүч, аж үйлдвэрийн технологийн хөгжлийн байгууллага /NEDO/ хооронд 2016 оны 02 дугаар сард “Нүүрсний хуурай баяжуулалтын технологийг Монголд нутагшуулахад хамтран ажиллах талаар Харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулсан ба тус санамж бичгийн хүрээнд Тавантолгойн ордод түшиглэн жилд 300 мян.тн нүүрсийг хуурай аргаар баяжуулах хүчин чадалтай загвар үйлдвэрийг байгуулах “Гүйцэтгэлийн гэрээ”-г Япон Улсын Нагата инженеринг болон Монголын “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хооронд байгуулж, холбогдох туршилт судалгааны, ажлыг хийж гүйцэтгэхээр тохиролцсон боловч 2017 оны 4-р сараас “Эрдэнэс Монгол” ХХК нь санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас уг төслийг хэрэгжүүлэх боломжгүйгээ илэрхийлсэн тул УУХҮЯ-наас “Энержи Ресурс” ХХК-д 2017 оны 5 дугаар сард санал тавьсны дагуу	40%

							“Энержи Ресурс” ХХК төслийг судлан үзэж, хамтран хэрэгжүүлэх боломжтой талаар саналаа илэрхийлсэн тул Санамж бичигт дурьдсан төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын нэр болон, ажлын графикийг өөрчлөх, төслийг хэрэгжүүлэх Нагата инженеринг компани болон “Энержи Ресурс” ХХК хооронд гүйцэтгэлийн гэрээг байгуулахаар холбогдох ажлууд хийгдэж байна.	
	МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.68 дахь заалт	“Алт-2” хөтөлбөрийг боловсруулсан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх	1. “Алт-2” хөтөлбөрийг боловсруулж батлуулах	Хөтөлбөр боловсруулах ажлын явц, хувиар	100.0		1. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1.дэх зүйл, 2 дугаар зүйлийн 2.68 дахь заалт, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд “Алт-2” хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх үүргийг Сангийн яам, Монголбанк, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд өгөгдсөний дагуу “Алт-2” хөтөлбөрийн төслийг Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны 403, А/68, А/136, А-339 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг эцэслэн боловсруулж 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 20 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 17 дугаар захирамжаар “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулан байгуулсан.	100%
			2. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх				2. Тус зөвлөлийн дарга буюу Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/42 дугаар тушаалаар Хууль эрх зүй, орон	100%

			нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулах				нутаг, Санхүүжилт, Геологи уул уурхай, Байгаль орчин нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан салбар зөвлөлийг байгуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн 2017 оны А/66, А-166 дугаар хамтарсан тушаалаар баталсан.	
			3. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх				3. Уг 5 зорилтын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг Салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн боловсруулж, хэрэгжилтийг сар бүр гарган ажиллаж байна. Үүнд: 1-р зорилтын хүрээнд: • Санхүүжилт шаардлагатай байгаа алтны 130 төслийн судалгааг гаргаж Хөгжлийн банкинд хүргүүлсэн ба одоогийн байдлаар Хөгжлийн банк зээллэг хүссэн 13 аж ахуйн нэгжийг судалж, материалын бүрдэл хангасан 3 аж ахуйн нэгжид 21,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. • Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулсан. • “Алт агуулсан хүдэр, элс олборлож баяжуулах, хамгаалах, хадгалах, хамгаалах, хүлээлцэх, тээвэрлэх худалдахтай холбогдсон журам”-ыг төслийг боловсруулж сонсох үйл ажиллагаа явуулж байна. 2-р зорилтын хүрээнд: • Алтны хэтийн төлөв бүхий бүс, нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр Монгол орны алтны хэтийн төлөвийг үнэлэх, алтны эрэл-үнэлгээний сэдэвчилсэн судалгааны ажлыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулсан. Тус сэдэвчилсэн судалгааны ажлыг 2017 онд Монгол орны төв, зүүн бүсийн хэмжээнд	100%

						гүйцэтгэхээр төсөв, төлөвлөгөө, геологийн даалгаврыг боловсруулан гүйцэтгэгч хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажил явагдаж байна. • Хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицолыг тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 37 тоот тогтоолыг батлуулсан. Хайгуулын тусгай тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицлыг 13.6 сая га-аар нэмэгдүүлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. • Алтны шороон ордын 13, үндсэн ордын 2 хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн улсын нөөцийн санг 3310,7 кг нөөцөөр нэмэгдүүлсэн. 3-р зорилтын хүрээнд: • Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/62, А-98 тоот хамтарсан тушаалаар Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголбанк, Стандарт хэмжил зүйн газар, “Эрдэнэс Монгол”ХХК - ийн төлөөлөл оролцсон Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн календарчилсан төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн технологийн харьцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэж байна. 4-р зорилтын хүрээнд: • Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/48 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо"-г шинэчлэн байгуулсан. • "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын түр журам"-ын төслийг боловсруулж, сонсох ажиллагаа явуулж байна.	
--	--	--	--	--	--	---	--

							5-р зорилтын хүрээнд: “Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам” болон “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын боловсруулан 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. “Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам” болон “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулж, дээрх 2 журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор батлуулсан.	
	МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.61 дэх заалт	Ашиглахад бэлэн болсон уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх, олборлолт, экспортыг нэмэгдүүлэх	1. Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т заасны дагуу ашиглахад бэлэн болсон уурхайг улсын комиссоор хүлээн авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0		1. 2017 онд нийт 46 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлсэн. Комисс ажлууллагаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоож бичиг баримтын бүрдэл хангасан 7 уурхайд Улсын комисс ажиллаж, цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгч, хүлээн авсан. Бусад бичиг баримтын бүрдэл хангалттай - 13, бичиг баримтын бүрдэл хангаагүй-18, бичиг баримтын бүрдэлээ ирүүлээгүй-13 аж ахуйн нэгж байна. Комисс 4 удаа ажилласан.	70%
	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 3, 4 ЗГҮАХ-ийн 2.71, 2.72, 2.73 дахь заалт	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалт ын ажлыг эрчимжүүлэх	1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг хүлээж авч	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл	100.0		1. “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолоор үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байгуулах, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны арваас доошгүй хувийг хөрөнгө	40%

			үнэлэлт, дүгнэлт өгөх	боловсруулах ажлын явц, хувиар			оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмшихээр тогтоосон. Уг тогтоолд тусгагдсан төслийн хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгчийг хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулах ажлын хүрээнд Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газраас санал авч Хөрөнгө оруулагч сонгох ерөнхий нөхцөл, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүд, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэгтэй холбогдолтой баримт бичгийн төслийг боловсруулсан. Уг баримт бичгийн төслийг зохих журмын дагуу батлуулахаар ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь сонгосон байршилд, техникийн нөхцөлүүд болон шаардлагатай зөвшөөрлүүдийг авна. Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 91 дүгээр тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн ойролцоо ирээдүйд байгуулагдах "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн салбар төмөр замыг "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замаас салаалах техникийн нөхцөлийн боломжийг судлан, дүгнэлт гаргахаар үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	
			2. Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн тайланг хүлээн авч, үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг хангах	"Уул уурхай металлургийн цогцолбор" төслийн 2 дугаар шатны бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	10.0		2. "Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ болон БОННҮ-ний дунд шатны тайлангуудыг хянаж, хүлээн авч цаашид гүйцэтгэх Банкны ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай санал, зөвлөмжийг ТЭЗҮ-г боловсруулж байгаа Канад Улсын "Hatch" компанид хүргүүлсэн. Эцсийн тайланг 2017 оны 9 дүгээр сард хүлээж авахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн уг ТЭЗҮ-ийн урьдчилсан тайланд Дэлхийн банкаар эксперт хийлгэх сэдэв,	40%

						бүлгийг сонгон дэлхийн банкны Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл /УУДБХОДТ/-д хүргүүлсэн.	
			3. Газар доогуур инженерийн шугам сүлжээ байгуулах ажлыг эхлүүлэх			3. Газар доогуур инженерийн шугам сүлжээг байгуулах зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэж байна.	40%
			4. Үйлдвэрийн барилгын ажлыг дуусган, тоног төхөөрөмжийг суурилуулж, үйлдвэрийг ашиглалтад оруулах			4. “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК нь евро стандартад нийцсэн, жилд 20 000 тонн ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай, давтах аргын технологитой үйлдвэрийг ашиглалтанд оруулж, 2017.01.28-ны өдөр нээлтээ хийсэн. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг Герман Улсын "Shuler" компани, бусад дагалдах төхөөрөмжийг Итали улсад үйлдвэрлэж, нийлүүлсэн.	100%
			5. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулж, төслийн бэлтгэл ажлыг хангах	Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх ажлын явц хувиар	100.0	5. Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн “Төслийн нэгж байгуулах” тухай 107 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолоор “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий төслийн нэгжийг байгуулахыг УУХҮЯ-ны сайдад даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/43 дугаар тушаалаар нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр, хий дамжуулах шугам хоолойн бүтээн байгуулалттай холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулах үүрэг бүхий төслийн нэгж байгуулагдсан.	100%
			6. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслийн урьдчилсан болон			6. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл”-ийн үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг 2017 оны 5 дугаар сарын 5-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн Хүнд	100%

			нарийвчилсан ТЭЗҮ-ийг хүлээн авч үнэлэлт, дүгнэлт өгөх				үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан.	
			7. Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээг хүлээн авч, үнэлэлт, дүгнэлт өгөх		100.0		7. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл”-ийн үйлдвэрийн “Бүс нутгийн байгаль, орчны үнэлгээний урьдчилсан тайлан”-г 2017 оны 05 дугаар сард ирүүлсэн ба “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний эцсийн тайлан”-г гэрээний дагуу 7 дугаар сард хүлээн авахаар ажиллаж байна.	70%
	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.63, 2.70 дахь заалт	Газрын тосны эрэл, хайгуул, олборлолтыг тогтвортой нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг барих бэлтгэл ажлыг хангах	1. Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулж, төслийн бэлтгэл ажлыг хангах	Нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах явц, хувиар	100.0		8. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэх төслийн нэгж байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг Сангийн яамтай хамтран боловсруулж яамдаас санал авч 2017 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг хуралдаанаар Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн “Төрийн өмчит компани” байгуулах тухай 92 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг хэрэгжүүлэх 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай” 108 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдсан.	100%
			2. Төслийн нарийвчилсан				2. Дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:	70%

			ТЭЗҮ-ийн эхний, дундын, эцсийн тайлангуудыг тус тус хүлээн авч үнэлэлт, дүгнэлт өгөх				1.УУХҮСайдын 2017 оны 2-р сарын 1-ний А/26 тоот тушаалаар “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой”-н нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгаврыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хэсгийн хурлыг тухай бүр хуралдуулж “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой”-н нарийвчилсан ТЭЗҮ хийж гүйцэтгэх Ажлын даалгаварын төслийг Монгол, Англи хэл дээр боловсруулан УУХҮЯ-ны ТНБД-аар батлуулсан. 2.ТНБД-ын 2017 оны 2-р сарын 9-ний өдрийн А/16 тоот тушаалаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэх Зөвлөх компанийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороог байгуулсан. 3.Үнэлгээний хороон тухай бүр хуралдаж “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн нарийвчилсан ТЭЗҮ хийж гүйцэтгэх Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерийн хүсэлт хүлээн авах зар болон тендерийн баримт бичгийн төслийг Монгол, Англи хэл дээр боловсруулж ТНБД-аар батлуулсан. 3.Тендерийн хүсэлт хүлээн авах зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2017 оны 2-р сарын 15-ий өдөр байршуулсан. 4. Үнэлгээний хороо тендерт оролцох хүсэлт ирүүлсэн БНЭУ-ын Экспорт-Импорт банкны шаардлага хангасан компаниудаас хураангуй жагсаалт үүсгэсэн бөгөөд хураангуй жагсаалтад багтсан компаниудад тендерийн баримт бичгийг ажлын даалгаварын хамт 2-р сарын 21-ний өдөр цахим шуудангаар болон буухиа шуудангаар эх хувиар нь хүргүүлсэн. Түүнчлэн дээрх баримт бичгүүдийг Монгол	
--	--	--	--	--	--	--	---	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

							Улсаас БНЭУ-д суугаа Элчин сайдын яам болон БНЭУ-ын Экспорт-Импорт банканд тус тус хүргүүлээд байна.	
Хэрэгжилтийн дундаж								72,3

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР